



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/54

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндөрхаан өргөө” ХХК-аас Хэнтий аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан хариуцагчаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д олгож, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР